



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2023/179/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: <a href="mailto:bolortuulb@audit.gov.mn">bolortuulb@audit.gov.mn</a>
Чойбалсан хот 2023 он	Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: <a href="mailto:semjidmaai@audit.gov.mn">semjidmaai@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: <a href="mailto:narmandakhd@audit.gov.mn">narmandakhd@audit.gov.mn</a>
	Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Ари файнэнс аудит" ХХК Утас: 99088151 Цахим хаяг: <a href="mailto:arifin.audit@gmail.com">arifin.audit@gmail.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас: Факс: 7058-4203

2023.08.24 № 214

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г ЧУЛУУНХОРООТ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Л.МӨНХЦЭЦЭГ ТАНАА

Г Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсрол шинжлэх ухааны яам 2022 оноос эхлэн төсвийн шинэчлэлийн хүрээнд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор чанар, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр Улсын төсвийн хуваарь болон санхүүжилт БШУЯ, БЕГ-аас шууд хуваарилагдан хянагдаж ирдэг болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах зорилгоор энэ хичээлийн жилээс Боловсролын нэгдсэн мэдээллийн систем /esis/-ийн бүх үйл ажиллагаа тухайлбал: багш ажилтан, ажилчдын өөрчлөгдсөн цалин, бусад нэмэгдлүүд,

011020198

**Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

холбоо барих мэдээлэл, байршил, үндэсний болон орон нутгийн сургалтад хамрагдсан байдал, сурагчдын үнэлгээ, харьяалал, байршил, асран хамгаалагчийн мэдээлэл, багш нарын цахим журналын шинэчлэл, санхүү, хөрөнгийн мэдээлэл, статистик мэдээлэл зэрэг үйлдлүүд шинэчлэгдэн өөрчлөгдсөнтэй холбогдуулан зохих журам тушаал, шийдвэрийн дагуу цаг хугацаанд нь мэдээллийг оруулснаар мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. Энэ нь БШУЯ болон бусад яамдуудын мэдээллийн эх үүсвэр болон ашиглагдаж байгаагаараа онцлог байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

**Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>152,444,921.50</b>	<b>261,624,333.84</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	<b>72,130,612.04</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	<b>72,130,612.04</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	<b>72,130,612.04</b>
31211	Төрийн сангийн харилцах	-	72,130,612.04
33	АВЛАГА	-	240,000.00
335	Бусад авлага	-	240,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	240,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	152,444,921.50	189,253,721.80
354	Хангамжийн материал	95,264,921.50	129,223,721.80
35420	Аж ахуйн материал	95,084,921.50	125,031,959.80
35460	Хүнсний материал	-	272,000.00
35470	Бусад хангамжийн материал	180,000.00	3,919,762.00
35600	Мал амьтад	57,180,000.00	60,030,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,811,436,594.74</b>	<b>1,815,973,497.02</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,811,436,594.74</b>	<b>1,815,973,497.02</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,795,876,594.74</b>	<b>1,800,413,497.02</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,612,605,290.10	1,612,605,290.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	(103,024,811.28)	(150,386,333.76)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	48,000,000.00	48,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(47,333,333.57)	(48,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	104,777,061.20	173,026,450.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(58,417,722.93)	(77,004,710.65)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	76,850,980.69	110,214,815.69
39208	Хуримтлагдсан элэгдэл	(51,408,536.92)	(63,573,032.53)
39209	Зам, гүүрийн байгууламж	72,882,900.00	72,882,900.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(7,112,357.60)	(14,433,792.68)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	18,000,000.00	18,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	123,141,478.00	123,141,478.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,343,948.65)	(24,066,147.05)
39217	Ном	18,259,595.70	20,006,579.70
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>15,560,000.00</b>	<b>15,560,000.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	15,560,000.00	15,560,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,963,881,516.24</b>	<b>2,077,597,830.86</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,963,881,516.24</b>	<b>2,077,597,830.86</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,963,881,516.24</b>	<b>2,077,597,830.86</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	366,667,453.88	366,667,453.88
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	351,107,453.88	366,667,453.88
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>958,973,578.44</b>	<b>1,072,689,893.06</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	958,973,578.44	(1,004,907,937.80)
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,077,597,830.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	638,240,483.92	638,240,483.92
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,963,881,516.24</b>	<b>2,077,597,830.86</b>

**Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>863,048,297.00</b>	<b>3,363,340,626.54</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>146,711,814.00</b>	<b>2,095,401,924.54</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>146,711,814.00</b>	<b>2,095,401,924.54</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	<b>2,028,700.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,028,700.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	98,571,814.00	1,884,865,802.74
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	48,140,000.00	208,507,421.80
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>716,336,483.00</b>	<b>1,267,938,702.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>646,865,600.00</b>	<b>858,641,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	858,641,500.00
<b>131007</b>	<b>Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих</b>	<b>646,865,600.00</b>	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>9,793,283.00</b>	<b>25,519,302.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,180,983.00	25,519,302.00
<b>131105</b>	<b>Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого</b>	<b>612,300.00</b>	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>59,677,600.00</b>	<b>383,777,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,677,600.00	383,777,900.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>867,432,226.43</b>	<b>1,285,742,795.68</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>867,432,226.43</b>	<b>1,285,742,795.68</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>836,094,785.85</b>	<b>1,224,888,402.56</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>543,195,613.00</b>	<b>606,124,566.00</b>
210101	Үндсэн цалин	379,344,293.00	416,164,313.00
210102	Нэмэгдэл	123,512,908.00	153,780,434.00
210104	Урамшуулал	40,338,412.00	36,179,819.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>71,862,683.51</b>	<b>75,960,665.46</b>
210201	Тэтгэврийн даатгал	50,546,393.98	52,212,178.61
210202	Тэтгэмжийн даатгал	5,465,778.68	6,128,527.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,352,482.87	4,872,582.30
210204	Ажилгүйдлийн даатгал	1,053,684.44	1,187,699.85
210205	Эрүүл мэндийн даатгал	10,444,343.54	11,559,676.74
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>54,329,422.91</b>	<b>277,015,296.88</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,607,572.91	9,464,503.92
210302	Түлш, халаалт	44,721,850.00	267,550,792.96
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>55,124,693.42</b>	<b>22,800,000.00</b>
210401	Бичиг хэрэг	632,900.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,226,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,916,925.00	

**Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,293,720.00	
210408	Бараа материал акталсны зардал	49,055,148.42	22,800,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>11,777,678.00</b>	<b>48,489,571.50</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,040,000.00	
210502	Хоол, хүнс	10,737,678.00	48,489,571.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,837,300.00</b>	<b>2,697,250.00</b>
210604	Урсгал засвар	2,837,300.00	2,697,250.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>655,000.00</b>	<b>72,370,800.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	295,000.00	67,610,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,760,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>96,312,395.01</b>	<b>119,430,252.72</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	13,336,347.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,339,000.00	7,270,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	94,973,395.01	98,823,305.72
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,337,440.58</b>	<b>60,854,393.12</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>13,237,753.00</b>	<b>59,666,349.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,739,385.00	34,147,047.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,498,368.00	25,519,302.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>6,392,427.09</b>	<b>1,188,044.12</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,392,427.09	1,188,044.12
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,707,260.49	
<b>213503</b>	<b>Төвлөрүүлэх шилжүүлэг</b>	<b>11,707,260.49</b>	
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(4,383,929.43)</b>	<b>2,077,597,830.86</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>9,765,850.14</b>	
<b>225001</b>	<b>Үндсэн хөрөнгө худалдсаны гарз</b>	<b>9,765,850.14</b>	
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(9,765,850.14)</b>	
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(14,149,779.57)</b>	<b>2,077,597,830.86</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>716,336,483.00</u></b>	<b><u>1,269,967,402.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>2,028,700.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	<b>2,028,700.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	<b>2,028,700.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,028,700.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>716,336,483.00</b>	<b>1,267,938,702.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>646,865,600.00</b>	<b>858,641,500.00</b>

**Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	858,641,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	646,865,600.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>9,793,283.00</b>	<b>25,519,302.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,180,983.00	25,519,302.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	612,300.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>59,677,600.00</b>	<b>383,777,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,677,600.00	383,777,900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>716,336,483.00</b>	<b>1,167,905,789.96</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>716,336,483.00</b>	<b>1,167,905,789.96</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>685,645,652.42</b>	<b>1,101,619,620.84</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>543,195,613.00</b>	<b>606,124,566.00</b>
210101	Үндсэн цалин	379,344,293.00	416,164,313.00
210102	Нэмэгдэл	123,512,908.00	153,780,434.00
210104	Урамшуулал	40,338,412.00	36,179,819.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>71,862,683.51</b>	<b>75,960,665.46</b>
210201	Тэтгэврийн даатгал	50,289,676.27	52,198,072.57
210202	Тэтгэмжийн даатгал	5,547,493.29	6,137,059.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,411,154.54	4,869,247.32
210204	Ажилгүйдлийн даатгал	1,064,232.77	1,159,770.62
210205	Эрүүл мэндийн даатгал	10,550,126.64	11,596,515.74
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>52,285,172.91</b>	<b>277,015,296.88</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,607,572.91	9,464,503.92
210302	Түлш, халаалт	42,677,600.00	267,550,792.96
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,348,615.00</b>	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,226,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,822,615.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>8,847,268.00</b>	<b>43,329,795.50</b>
210502	Хоол, хүнс	8,847,268.00	43,329,795.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,317,300.00</b>	<b>2,697,250.00</b>
210604	Урсгал засвар	1,317,300.00	2,697,250.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>655,000.00</b>	<b>72,720,800.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	295,000.00	67,610,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	5,110,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,134,000.00</b>	<b>23,771,247.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	14,406,847.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,134,000.00	9,364,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,690,830.58</b>	<b>66,286,169.12</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>12,591,143.00</b>	<b>65,098,125.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,092,775.00	39,578,823.00

**Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,498,368.00	25,519,302.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>6,392,427.09</b>	<b>1,188,044.12</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,392,427.09	1,188,044.12
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	11,707,260.49	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,707,260.49	
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	≡	<b>102,061,612.04</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	-	<b>29,931,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>29,931,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	<b>29,931,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		29,931,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	≡	<b>(29,931,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	<b>72,130,612.04</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	72,130,612.04

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	366,667,453.88	638,240,483.92	(1,004,907,937.80)	
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>366,667,453.88</b>	<b>638,240,483.92</b>	<b>(1,004,907,937.80)</b>	-
Тайлант үеийн үр дүн	-	-	2,077,597,830.86	<b>2,077,597,830.86</b>
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>366,667,453.88</b>	<b>638,240,483.92</b>	<b>1,072,689,893.06</b>	<b>2,077,597,830.86</b>

**2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,244,448,100.00</b>	<b>1,171,129,443.84</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,244,448,100.00</b>	<b>1,171,129,443.84</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,202,839,900.00</b>	<b>1,131,550,620.84</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>664,881,575.00</b>	<b>606,124,566.00</b>
210101	Үндсэн цалин	494,249,004.00	416,164,313.00
210102	Нэмэгдэл	147,294,626.00	153,780,434.00
210104	Урамшуулал	23,337,945.00	36,179,819.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>83,222,034.00</b>	<b>75,960,665.46</b>
210201	Тэтгэврийн даатгал	56,661,734.00	52,198,072.57
210202	Тэтгэмжийн даатгал	6,662,100.00	6,137,059.21

**Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210203	ҮОМШӨ-ний даатгал	5,316,200.00	4,869,247.32
210204	Ажилгүйдлийн даатгал	1,325,700.00	1,159,770.62
210205	Эрүүл мэндийн даатгал	13,256,300.00	11,596,515.74
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>277,015,296.88</b>	<b>277,015,296.88</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,464,503.92	9,464,503.92
210302	Түлш, халаалт	267,550,792.96	267,550,792.96
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>43,330,000.00</b>	<b>43,329,795.50</b>
210502	Хоол, хүнс	43,330,000.00	43,329,795.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	<b>2,697,250.00</b>	<b>2,697,250.00</b>
210604	Урсгал засвар	2,697,250.00	2,697,250.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>75,041,544.12</b>	<b>72,720,800.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,798,544.12	67,610,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,243,000.00	5,110,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>56,652,200.00</b>	<b>53,702,247.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,287,800.00	44,337,847.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,364,400.00	9,364,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>41,608,200.00</b>	<b>39,578,823.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>41,608,200.00</b>	<b>39,578,823.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	41,608,200.00	39,578,823.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,244,448,100.00</b>	<b>1,243,260,055.88</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>858,641,500.00</b>	<b>858,641,500.00</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	858,641,500.00	858,641,500.00
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>2,028,700.00</b>	<b>2,028,700.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,028,700.00	2,028,700.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>383,777,900.00</b>	<b>382,589,855.88</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	383,777,900.00	382,589,855.88
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	72,130,612.04

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>25,519,302.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>25,519,302.00</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	25,519,302.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	25,519,302.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,519,302.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	25,519,302.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	25,519,302.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,519,302.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 4 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 2 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

#### 3.2 Албан шаардлага

##### 1. Хөрөнгөтэй холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1. "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" заалт; 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

##### 2. Худалдан авалттай холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 17 дугаар зүйлийн 17.1. "Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана", 30.4. "Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана", 30.4.1 "тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах", 30.4.2 "энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах", 30.4.3 "энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах", 34 дүгээр зүйлийн 34.3 "Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

#### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### Орлогын бүртгэлтэй холбоотой асуудал

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриар бүртгээгүйгээс орлогыг дутуу илэрхийлсэн байх, нотлох баримтгүй, тайлан тооцоо гаргаж ажиллаагүй зэрэг зөрчил гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалттай нийцээгүй, "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриар бүртгэн бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

### 2. Зардалтай холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Сурагчдын хоолны санхүүжилтийг esis.edu цахим системд сурагчдын өдөр тутмын ирцийг хөтлөн няравын тайланд бүртгэж тооцоо хийдэггүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно" гэж 5 дугаар зүйлийн 5.1.1 Үнэн зөв байх гэсэн заалтуудтай нийцээгүй, иж бүрэн, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Үүнээс Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.	1	-			1	-		
Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан.	1	-			1	-		
Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриар бүртгээгүйгээс орлогыг дутуу илэрхийлсэн байх, нотлох баримтгүй, тайлан тооцоо гаргаж ажиллаагүй зэрэг зөрчил гаргаж бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан байна.	1	-					1	-
Сурагчдын хоолны санхүүжилтийг esis.edu цахим системд сурагчдын өдөр тутмын ирцийг хөтлөн няравын тайланд бүртгэж тооцоо хийдэггүй	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>-</b>			<b>2</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>

**Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 69/61 ДАА-2023/179/НА-СТА-ТШЗ

Чойбалсан хот

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1. "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" заалт; 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.2 "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эд хөрөнгийн тооллого хийгдсэний дараа хөрөнгийн тооцоог бодож, тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулсан байх, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Л.Мөнхцэцэг, нягтлан бодогч И.Оюунтунгалаг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕР  
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ийн  
ЗАХИРАЛ



И.СЭМЖИДМАА

Д. АРИУНАА

011040389

**Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 79/02 ДДН-2023/179/НА-СТА-ТМЗ Чойбалсан хот

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 17 дугаар зүйлийн 17.1. "Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана", 30.4. "Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана", 30.4.1 "тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах", 30.4.2 "энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах", 30.4.3 "энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах", 34 дүгээр зүйлийн 34.3 "Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

011040397

**Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, алдаа зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Л.Мөнхцэцэг, нягтлан бодогч И.Оюунтунгалаг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕР

АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

 И.СЭМЖИДМАА

 Д. АРИУНАА

